

Монгол Улсад эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцоо үүсэн хөгжсөн түүхэн тойм

Чулууны Алтанцэцэг ✉ 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ chuluunalt@gmail.com

Отгондоогийн Алтанзаяа 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсад эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцооны үүсэл, өөрчлөлт, эрх зүйн болон институцийн зохион байгуулалтын хөгжлийг архивын баримт, тогтоол, тушаал, хэвлэгдсэн бүтээлүүдэд тулгуурлан тоймлов. Эрдмийн зэрэгтэй хүмүүсийг 1921-1945 онд гадаадад (голлон ЗХУ) бэлтгэж, хамгаалуулах үйл ажиллагаа давамгайлж байсан бол, 1940-1990 онд дотоодын их, дээд сургууль болон шинжлэх ухааны байгууллагуудын дэргэд зөвлөлүүд байгуулагдан “дэд эрдэмтэн-доктор” гэсэн эрдмийн зэрэг, “доцент-профессор” цол олгох төвлөрсөн баталгаажуулалт (Дээд комисс)-тай тогтолцоо төлөвшсөн. 1990 оноос олон улсын жишигт нийцүүлэн магистр, доктор (Ph.D) ба шинжлэх ухааны доктор (Sc.D) зэрэг бүхий кредитэд суурилсан сургалт, хамгаалуулах зөвлөлөөр баталгаажуулах хэлбэрт шилжив. Соёл, урлаг судлалын чиглэлд 1978 оноос дотоодын хамгаалалтууд эхэлсэн нь салбарын хөгжлийн чухал үе шат байв. Тойм нь өнөөгийн байдал, цаашдын бодлого тодорхойлоход судлаачдад суурь лавлах болно.

Түлхүүр үгс: аспирантур, хамгаалуулах зөвлөл, Ph.D, Sc.D, дээд боловсролын бодлого, дүрэм, журам

Historical Development of the Academic Degree and Title System in Mongolia

Altantsetseg Chuluun ✉ 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of
Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ chuluunalt@gmail.com

Altanzaya Otgondoo 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University of
Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This article provides a historical overview of the development and transformation of Mongolia’s academic degree and title system based on archival materials, government decrees, and scholarly sources. During 1921–1945, academic training was primarily conducted abroad, especially in the Soviet Union. Between 1940 and 1990, domestic universities and research institutions established academic councils, adopting a two-tiered system of “Candidate of Science–Doctor of Science” and the academic titles “Associate Professor–Professor,” under centralized supervision by the Higher Attestation Commission. Since the 1990s, Mongolia has transitioned to an internationally recognized framework comprising Master, Doctor (Ph.D) and Doctor of Science (Sc.D) degrees, integrating credit-based doctoral programs and decentralized defense councils within universities. The field of culture and art studies marked a milestone in 1978 with the first domestic dissertation defense, laying the foundation for independent scholarly development. This study highlights the evolution of institutional policies, the legal framework, and the continuing need for quality assurance and international alignment in Mongolia’s academic degree system.

Keywords: *academic degree, attestation commission, Ph.D, Sc.D, higher education policy*

Оршил

Монгол Улсад орчин цагийн анхны сургуулийг 1912 оны 3-р сарын 24-нд Монгол Улсын Засгийн газраас Гадаад яамны дэргэд Нийслэл хүрээ, Түшээт хан аймаг, Сэцэн хан аймгаас ирсэн 47 сурагчтайгаар нээж, сургуулийн асуудлыг Ж.Цэвээнд даатгаж, иргэний анхны сургууль байгуулагдаж боловсролын ерөнхий түвшнийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг (БШУЯ 2021, 21).

Эрдмийн зэрэг, цол олгох тухай асуудал бүх ард түмнийг соён гэгээрүүлэх, багш, судлаачдын чадавхыг сайжруулах, хүмүүст сурч боловсрох, судалгааны зэрэг цолоо ахиулах зэрэг нийгмийн шаардлагаар бий болсон ажээ. Мөн Монгол Улсад албан ёсоор докторын зэрэг хамгаалах тухай асуудал нь тухайн салбарын горилогч нь гадаадад хамгаалдаг байсныг больж боловсрол, шинжлэх ухаан монголдоо хөгжин дэлгэрэх, судлаач, багш нарыг эрдэмжүүлэх нийгмийн шаардлагаар эх орондоо хамгаалуулдаг болжээ. Эрдмийн зэрэг (academic degree) нь “Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа хийж нэг сэдэвт бүтээл туурвин амжилттай

хамгаалсан хүнд олгодог зэрэг дэв. Магистрын, докторын, шинжлэх ухааны докторын зэрэг гэж байна” (БШУЯ 2021, 764) гэжээ.

Эрдмийн зэрэг хамгаалуулах үндсэн хэлбэр болох диссертац (лат. *dissertatio*)¹ нь тодорхой хугацаанд гүйцэтгэсэн судалгааны үр дүнг баримт, арга зүйтэй нь нэгтгэн илэрхийлсэн гар бичмэлийн эрхтэй бүтээл бөгөөд олон улсын нийтлэг шаардлагын дагуу зөвлөл дээр нээлттэй хэлэлцүүлж хамгаалдаг уламжлал XXI зуунд ч хадгалагдаж байна.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Монгол Улсад эрдмийн зэрэг хамгаалах тогтолцоо үүсэн хөгжсөн түүхэн тоймыг гурван үеэр ангилан авч үзэв. (1) 1921–1945: гадаад бэлтгэл (ЗХУ-д төвлөрсөн), (2) 1940–1990: БНМАУ дахь дотоодын тогтолцоо, (3) 1990 оноос өнөөг хүртэл: олон улсын жишигт нийцсэн шинэ шатлал. Үндэсний төв архив (МУУТА), Засгийн газрын архив (МУЗГА), ШУА болон холбогдох байгууллагын фонд (ф.), данс (д.), хадгаламжийн нэгж (хн.)-ийн эх баримтууд, холбогдох дүрэм, журам, тогтоолууд, мөн хэвлэгдсэн бүтээлүүдийг үндсэн эх сурвалж болгов. Энэхүү өгүүллийг бичихдээ ажиглалт, харьцуулалт, нэгтгэн дүгнэх аргыг ашиглав. Монгол Улсад бий болсон эрдмийн зэрэг цолны тогтолцооны асуудлыг гаргахдаа архивын эх хэрэглэгдэхүүнийг гол болгон ашиглав.

Судалгааны үр дүн

• ЗХУ болон бусад оронд эрдэмтэн бэлтгэсэн үе (1921–1945)

1921 оноос хойш Ардын засгийн газар шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх зорилго тавьж, залуучуудыг ЗХУ-д илгээж эхэлсэн.

1934 онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Улс (ЗХУ)-д эрдмийн зэрэг, цол олгох тогтолцоог хуульчилсан байдаг.² Эрдмийн зэргийг олгохдоо “Кандидат наук” (шинжлэх ухааны кандидат) ба “Доктор наук” (шинжлэх ухааны доктор) гэсэн хоёр шатлалт системийг нэвтрүүлсэн байна. “Доцент” ба “Профессор” гэсэн эрдмийн цолыг шинээр тогтоож, эрдэм шинжилгээний байгууллагууд болон их дээд сургуулиудад хэрэгжүүлжээ. Эрдмийн зэрэг хамгаалахын тулд аспирантурт суралцах тогтолцоог бий болгосон байна.

Энэ тогтоолоор судалгааны ажлын үр дүнгээр диссертац бичиж эрдмийн зөвлөлөөр хамгаалах бөгөөд эрдмийн зэрэг, цол олгох эрхийг зөвхөн тодорхой байгууллагуудад (Аттестачлалын дээд комисс, Высшая аттестационная комиссия - ВАК) олгож, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан байна. Манай тэр үеийн эрдэмтэн, судлаачид анагаах ухаан, техник технологи, хэл шинжлэл, түүх,

¹ Латин хэлний “*dissertātiō*” буюу судалгаа, эх зохиол, илтгэл гэсэн утгатай үгээс гаралтай бөгөөд англиар “*thesis*” (оюуны санаанд хамаарах ямар нэг зүйлийг оруулсан гэсэн утгатай грек үгээс гаралтай) гэж оноодог. “*Thesis*” нь судалгааны ажлын үндсэн үр дүнг тайлбарласан бичвэр бөгөөд эрдмийн зэрэг эзэмшихэд тавигдах үндсэн шаардлагуудын нэг. Горилогчийн тодорхой хугацаанд хийсэн судалгааны үр дүнг боловсруулсан мэдээллийг агуулсан гар бичмэлийн эрхтэй бүтээл. Диссертац нь тодорхой журмын дагуу бичигддэг бөгөөд эрдэм шинжилгээний хэвлэлд зохиогчийн нийтэлсэн материалд тулгуурладаг онцлогтой.

² 1934 оны 1-р сарын 13-нд ЗХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөл (СНК СССР) “Об ученых степенях и званиях” нэртэй 79-р тогтоолыг баталсан нь орчин үеийн эрдмийн зэрэг, цолны тогтолцооны үндэс суурь болсон байдаг.

байгалийн ухааны чиглэлээр ЗХУ-д суралцаж, кандидат наук болон докторын зэргийг хамгаалсан байдаг.

- ***БНМАУ-д эрдмийн зэрэг, цол олгох тогтолцоог нэвтрүүлсэн нь (1940-1990)***

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн (СнЗ) 1940 оны 12 дугаар сарын 6-ны 45-р тогтоолоор Улаанбаатар хотноо улсын университет байгуулах 45-р тогтоол гарч, 1942 онд Монгол Улсын их сургууль байгуулагдаж, нарийн мэргэжлийн боловсон хүчин төрөн гарч, дотооддоо багш, судлаачдыг бэлтгэх эхлэл тавигдсан.

Монголын төр, засаг шинжлэх ухааны ба сурган хүмүүжүүлэх ухааны ажилтны мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний судалгааны ажлыг урамшуулах зорилгоор дэд эрдэмтэн, шинжлэх ухааны докторын зэрэг, ассистент, доцент, профессор цол олгох тухай шийдвэрийг Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 9 дүгээр сард гаргасан нь Монгол Улсад шинжлэх ухааныг хөгжүүлэх, боловсон хүчнийг бэлтгэхэд чухал ач тустай болжээ (Лхамцэрэн 2017, 15).

1946 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн МУИС-ийн Ректорын 84 тоот тушаалаар МУИС-д аспирантурыг байгуулж, анхны төгсөгчдөөс 9 хүнийг 7 дугаар сарын 1-ээс эхлэн тус сургуулийн тэнхимүүдэд аспирантаар томилж, тухайн үедээ өндөр цалин олгохоор болжээ (Лхамцэрэн 2017, 15). Тун удалгүй Д.Цэвэгмид /биологи/, Ж.Жамсран /хими/, Ц.Жамьянжав, П.Шинжээ, Ц.Тойвгоо /мал эмнэлэг/ нар хамгаалж МУИС-ийн анхны эрдэмтэд болсон түүхтэй ажээ (Төмөр-Очир, Ринчинбазар, Дэлгэржаргал 2022, 27).

БНМАУ-ын СнЗ ба МАХН-ын Төв Хорооны 1957 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 303/223-р тогтоол, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Зарим яамд, тусгай газруудыг нэгтгэх тухай” 94 дүгээр зарлиг гарч “Улсын их сургуулийг Шинжлэх ухааны хүрээлэнтэй нэгтгэж БНМАУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн болгосугай” гэжээ (Алимаа, Болормаа, Боролзой ба бусад 2021, 115). Энэ үеэс эхлэн Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн нь эрдэмтэн, профессор нарын оюуны хүч чадамжийг сайжруулах, төвлөрүүлэх төв болсон байна.

1953 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн БНМАУ-ын СнЗ-ийн 207-р тогтоолоор СнЗ-ийн дэргэд Шалгалтын дээд комисс байгуулж, “Шалгалтын дээд комиссын дүрэм”, “Эрдмийн цол олгох журмын тухай дүрэм”-ийг тус тус баталсан байна. БНМАУ-ын СнЗ ба МАХН-ын Төв Хорооны 1957 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ”Эрдмийн зэрэг цол олгох журмын тухай” 472/402 дугаар тогтоолд “... Шинжлэх ухааны доктор, дэд эрдэмтэн гэдэг эрдмийн зэрэг, профессор, доцент гэдэг эрдмийн цолыг Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэнгийн эрдэмтдийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр олгож байх эрхийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх эрдмийн зэрэг цол олгох улсын комисст олгосугай” гэжээ. Энэ тогтоолын 3 дугаар зүйлд “Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх эрдмийн зэрэг цол олгох улсын комисст үүрэг болгох нь: а/ шинжлэх ухааны чухал асуудлыг шийдвэрлэсэн буюу эсвэл онолын дүгнэлт хийсэн эрдэм шинжилгээний бие даасан бүтээл болж чадсан докторын эрдмийн зохиолын хамгаалсан дэд эрдэмтэнд докторын зэргийн олгож байсугай; б/ аспирантурыг төгсгөж/ эсвэл зохих шалгалтаа өгч/, тогтоосон сэдвээр дэд эрдэмтний зохиолыг амжилттай хамгаалсан хүмүүст

/хэрэв уг зохиол нь тэр хүний шинжлэх ухааны тухайн салбарын талаар онолын ерөнхий мэдлэгтэй ба хамгаалсан асуудлын талаар гүнзгий мэдлэгтэйг нь үзүүлсэн бөгөөд цаашид эрдэм шинжилгээний ажлыг бие даагаад хийж чадах чадалтайг нь харуулсан байдал/ дэд эрдэмтэн зэрэг олгосугай” гэжээ (МУ-ын УТА. ф 4, х 23, хн 207, 256, 257). Энэхүү тогтоол нь манайд ЗХУ-ын жишгээр эрдмийн зэрэг, цол олгох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1961 онд Шинжлэх ухааны академи (ШУА) байгуулагдаж, монгол эрдэмтдийг дотооддоо системтэй бэлтгэх суурь тавигдсан. ШУА болон дээд боловсролын байгууллагуудын дэргэд диссертацийн зөвлөл байгуулагдаж, дотооддоо дэд эрдэмтэн, докторын зэрэг хамгаалах боломжоор хангагдсан.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1963 оны 7 дугаар сарын 17-ны тогтоолоор ШУА-ийн дэргэд эрдмийн зэрэг цолтой, төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн аспирантурын орон тооны бус зөвлөлийг байгуулж, тус зөвлөлийн өдөр тутмын ажлыг эрхлүүлэхээр нарийн бичгийн даргын орон тоог бий болгохыг зөвшөөрч (Монц, Дуламсүрэн 1970, 131), энэ үеэс эдүгээг хүртэл ШУА, хүрээлэнгүүдэд эрдмийн зэрэг, цол хамгаалуулах эрдмийн зөвлөл ажиллаж ирсэн түүхтэй.

БНМАУ-ын СнЗ-ийн 1969 оны 3 дугаар сарын 28-ны 86 тоот тогтоолоор “Дээд сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэр гаргаж “...дээд сургуулийн сургалтыг шинжлэх ухааны орчин үеийн түвшинд зохион явуулахад профессор, багш нарын эрдэм шинжилгээний ажил эрхлэн явуулах нь тэдний үндсэн үүрэг болохыг онцлон зааж..”, аспирантурт сургах, докторын зэрэг хамгаалахад бэлтгэх, эрдэм шинжилгээний ажил хийлгэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Мөн 1969-1970 оны хичээлийн жилээс *дээд сургуулийн дэргэд аспирантур байгуулахыг* Ардын боловсролын яаманд даалгасан байна (МУ-ын УТА. ф 6, х 4, хн 146, 2).

Мөн дээд сургуулийн багш нарыг эрдэмжүүлэх, шинжлэх ухааны бүх салбарт ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан болон судалгаа хийдэг хүний тоо нэмэгдэх зэрэг шалтгаанаар эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлд өөрчлөлт гарч бүрэлдэхүүнийг үе, үе шинэчилж байжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1969 оны 7 дугаар сарын 9-ний 237 тоот тогтоолын 2-р хавсралтаар шинжлэх ухааны доктор бэлтгэх зааврыг баталсан байна (МУ-ын Засгийн газрын архив. ф 1, д 27, хн 1, 80).

Эрх зүйн баримт бичиг дэх тогтоол, дүрэм, журмаас үзэхэд нэршлийн хувьд “Эрдмийн зэрэг, цол олгох улсын комисс”, “Эрдмийн зэрэг, цол олгох дээд комисс” зэргээр эрдмийн зэрэг, цол олгох түүхэн нөхцөлтэйгөө уялдан өөрчлөгдөж байсан ажээ. Тухайлбал, БНМАУ-ын СнЗ-ийн 1973 оны 8 дугаар сарын 17-ны 310 тоот тогтоолд “...1. СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох улсын комиссыг СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох дээд комисс гэж нэрлэсүгэй. 2. Эрдмийн зэрэг, цол олгох журмын тухай зааврыг баталсугай. 3. Эрдмийн зэрэг, цол олгох дээд комисст зөвшөөрөх нь а/ дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх эрдмийн зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүнийг хянан баталж байсугай.” б/ дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагын дэргэд эрдмийн зэрэг олгох зөвлөл тус бүр шинжлэх ухааны ямар салбараар эрдмийн зэрэг олгож байхыг

тогтоож өгч байсугай...” (МУ-ын Засгийн газрын архив. ф 1, д 27, хн 1, 41) хэмээн тогтоож байжээ. Энэ үед эрдмийн зэргийг ШУА, МУИС, ПДС зэрэг сургуулиудын дэргэдэх эрдмийн зөвлөлүүд хамгаалуулж, Эрдмийн зэрэг цол олгох дээд комисс баталгаажуулж байсан байна.

Монгол Улсад анх 1978 онд урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэргийг Л.Сономцэрэн хамгаалсан тухай дараах баримт бий. Үүнд, БНМАУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн цол, зэрэг хамгаалах эрдмийн зөвлөлийн 1978 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 5 тоот тогтоолоор ХЗХ-ийн Урлаг судлалын сектор³-ын эрдэм шинжилгээний ажилтан Л.Сономцэрэн “Монголын шинэ цагийн дүрслэх урлаг” гэдэг сэдвээр урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг горилжээ (МУ-ын УТА. ф 287, х 1, хн 203, 65). Горилогчийн удирдагчаар доктор С.Лувсанвандан, албан ёсны шүүмжлэгчээр философийн ухааны доктор С.Норовсамбуу, урлаг судлалын ухааны дэд эрдэмтэн Н.Цүлтэм, Г.Ринчэнсамбуу нарыг томилсон байдаг (МУ-ын УТА. ф 287, х 1, хн 203, 30).

БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 12 дугаар сарын 1-ний 464 дүгээр тогтоолын “Аспирантур, дэд эрдэмтний зэрэг горилогчийн дүрэм” баталж байсан ба 1984 оны 1 дүгээр сарын 6-нд “Аспирантурын дүрэм батлах тухай” 02 тоот тогтоолоор өөрчлөлт оруулж байжээ. Мөн олон жил шинжлэх ухааны салбарт үр бүтээлтэй ажилласан эрдэмтдэд бүтээлээр нь шинжлэх ухааны докторын зэргийг олгодог байсан байна. Жишээ нь, БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох улсын комиссын 1972 оны 11 дүгээр сарын 2-ны 2 тоот тогтоолд “БНМАУ-ын СнЗ-ийн 1968 оны 1 дүгээр тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны докторын зэрэг горилогч нарын тухай заавар”-ыг үндэслэн эрдэм шинжилгээний бүтээлээр нь БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн хүндэт гишүүн Ю.Цэдэнбалд эдийн засгийн ухааны докторын зэрэг, жинхэнэ гишүүн Ш.Лувсанванданд хэл бичгийн шинжлэх ухааны докторын зэрэг, дэд эрдэмтэн Ш.Нацагдоржид түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг, дэд эрдэмтэн Ц.Дамдинсүрэнд хэл бичгийн шинжлэх ухааны докторын зэрэг, дэд эрдэмтэн Т.Шагдарсүрэнд анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг, дэд эрдэмтэн Ш.Цэгмидэд газар зүйн шинжлэх ухааны докторын зэрэг, дэд эрдэмтэн Д.Цэвэгмидэд биологийн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус олгохоор тогтоосугай” (МУ-ын УТА. ф 287, д 2, хн 3, 61) хэмээн албан ёсоор олгож байсан ажээ.

БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссын 1987 оны 2 дугаар сарын 15-ны 01 тоот тогтоолд эрдмийн зэрэг олгох чиглэл, индексийг Монгол утга зохиол, утга зохиол судлал (05.04.01.00), Утга зохиолын түүх (05.04.01.01), Азийн ард түмний утга зохиол (05.04.01.05), Ардын аман зохиол (05.04.02.22), Монгол хэл шинжлэл (05.04.04.00), Харьцуулсан хэл шинжлэл (05.04.02.20), Монгол хэлний зүй (05.04.02.15), Урлаг судлал (05.08.00.00), Театрын урлагийн онол, түүх (05.08.01.00), Дүрслэх урлагийн онол, түүх (05.08.04.00), Чимэх, чимэглэх урлагийн онол, түүх (05.08.05.00) хэмээн баталсан байна. Эдгээр асуудлаар диссертац хэлэлцэж, хэл бичиг, урлаг судлалын ухааны эрдмийн зэрэг олгох байхыг зөвшөөрч байжээ (МУ-ын УТА. ф 287, д 3, хн 1, 2-3).

³ Тус сектор нь 1989 оноос эдүгээгийн Соёл, урлаг судлалын хүрээлэн болон өргөжиж өрх тусгаарласан түүхтэй.

Урлаг судлаач Б.Бадрахын намтарт БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссын 1985 оны 11 дүгээр тогтоолоор урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг, мөн комиссын 1991 оны 7 тоот тогтоолоор доцент цол олгожээ (Сүхтоого 2010, 188).

1991 онд Ж.Энэбиш докторын зэрэг горилох шат дараалсан үйл явц ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд хэрэгжиж байжээ. Тухайлбал, хөгжим судлалын анхны доктор Ж.Энэбишийн дэд эрдэмтний зэрэг хамгаалсан тухай тогтоолд “БНМАУ-ын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн тогтоол 1988 оны 2 дугаар сарын 16-ны өдөр №5. Дэд эрдэмтний зэрэг горилогчоор батлуулах тухай тогтоолын 2-т Ж.Сэржээ, Ж.Энэбиш, О.Сүхбаатар нарын бичсэн ганц сэдэвт зохиол нь дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн шаардлагыг хангасан тул Ж.Сэржээ, Ж.Энэбиш, О.Сүхбаатар нарт дэд эрдэмтний зэрэг горилогчоор баглах нь зүйтэй гэж үзсүгэй. Эрдмийн зөвлөлийн дарга, ШУА-ийн сурвалжлагч гишүүн, доктор, профессор П.Хорлоо, нарийн бичгийн дарга, доктор Д.Ёндон гэжээ” (Энэбиш 2018, 21).

• **1990 оноос өнөөг хүртэл**

Ардчиллын дараахан дээд боловсролын салбар шинэчлэгдэж, олон улсын бакалавр, магистр, доктор (Ph.D) гэсэн сургалтын шаталсан тогтолцоо руу шилжсэн. Дэд эрдэмтэн, доктор гэсэн нэр томъёо нь дэд доктор, доктор (Ph.D), доктор (Sc.D) (шинжлэх ухааны доктор) гэсэн байдлаар өөрчлөгдсөн.

Эрдмийн зэрэг, цол олгох тогтолцоог дэлхий нийтийн жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн “Монгол Улсад эрдмийн зэрэг, цол олгох тогтолцоог өөрчлөх тухай” 72 тоот тогтоолыг гаргажээ. Үүнд,

1. Монгол Улсын эрдмийн зэргийг бакалавр, магистр, дэд доктор, доктор; эрдмийн цолыг профессор, дэд профессор байхаар тогтоосугай. 2. Эрдмийн зэрэг, цол олгох түвшнийг хангасан их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн шийдвэрээр эрдмийн зэрэг, цол олгож, докторын зэрэг, профессор цолыг эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөл баталгаажуулж байх нь зүйтэй гэж үзсүгэй. 4. а/ Эрдмийн зэрэг, цолны одоогийн мөрдөж байгаа ангиллыг шинэ ангилалтай хэрхэн уялдуулах тухай асуудлыг боловсруулж Засгийн газарт оруулах, в/ их сургуулиудыг “Их сургуулийн статус”-ын дагуу зэрэглэлд оруулан зохион байгуулах, 5. Монгол Улсад эрдмийн зэрэг, цол олгох тогтолцоог өөрчилж байгаатай уялдуулан Засгийн газрын дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссыг 1992 оны 6 дугаар сард багтаан татан буулгасугай. 7. Энэ тогтоолыг 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй (МУ-ын Засгийн газрын архив. ф 1, д 27, хн 1, 9) хэмээн тогтоожээ.

1993 онд “Дээд боловсрол, эрдмийн зэрэг олгох сургуулиудыг зэрэглэх журам тогтоох тухай” БСШУ-ны сайдын № 47 тоот тушаал гарч байжээ.

ШУБ-ын сайдын 1995 оны 245 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын дээд боловсролын зэрэг олгох журам”-ын дагуу СУИС сургалтын баримт бичгүүдийг боловсруулж, эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж баталгаажуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулжээ (Сүхтоого 2010, 171).

Дээд сургуулиуд Монгол Улсын Засгийн газрын “Эрдмийн зэрэг, цол олгох

тогтолцоог өөрчлөх тухай” 1996 оны 63 тоот тогтоолыг дагаж энэ үеэс ахисан түвшний сургалтыг явуулж эхэлсэн байдаг. Докторын сургалт зохион байгуулах, зэрэг хамгаалуулахад Шинжлэх ухаан, боловсролын сайд, Эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөлийн даргын 1996 оны 247 тоот тушаалаар баталсан дүрмийг баримталж байв.

Монгол Улсын их хурлын 1998 оны 80 дугаар тогтоол, Монгол улсын Засгийн газрын 1998 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн Гэгээрлийн сайдын 1998 оны 281 дүгээр тушаалаар “Магистр, докторын зэргийн сургалт явуулахад баримтлах нийтлэг журам”-ыг баталж, Шинжлэх ухаан, боловсролын сайд, Эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөлийн даргын 1996 оны 247 тоот тушаалыг хүчингүй болгожээ. Энэ тушаалаар “...Энэхүү журам гарахаас өмнө олгосон шинжлэх ухааны докторын зэргийг үргэлжлүүлэн, дэд докторын зэргийг доктор (Ph.D) зэрэгтэй дүйцүүлэн хэрэглэх”, шинжлэх ухааны докторын зэрэг олгох ажлыг ШУА-д хариуцахаар заасан байна. Мөн докторын сургалт эрхэлж байгаа их сургуулиудад Дээд боловсролын хуульд заасны дагуу 1998-1999 оны хичээлийн жилд багтааж сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг даалгасан байна. Энэ журмаар өмнөх сургалтын кредит цагийг оролцуулан докторын сургалт нь нийт 210 (үүнээс 60 кредитээс цөөнгүй нь докторын түвшний сургалтад хамаарах) кредит цагаас доошгүй сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхийг заажээ.

Ийнхүү 2000 оноос хойш докторын зэрэг олгох үйл ажиллагаа нь олон улсын жишгийн дагуу дээд боловсролын бакалавр-магистр-доктор гэсэн сургалтын шаталсан тогтолцооны нэг хэсэг болж өөрчлөгдсөн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Боловсролын сайдын 2002, 2003, 2007, 2010, 2021, 2023 оны удаа дараагийн тушаалуудаар “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах журам” болон “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийг шинэчлэн мөрдүүлсээр иржээ. Эдгээр журамд докторын сургалтын 60 кредитэд диссертац бичиж хамгаалах кредит (12 кредит байснаа сүүлд 24 кредит болсон)-ийг тусгайлан зааж өгсөн байдаг. Докторант сургалтын кредитийг цуглуулж, судалгааны үр дүнгээр диссертац бичиж, доктор (Ph.D)-ын зэргийг салбарын яамнаас их дээд сургуулиудыг түшиглэн байгуулсан “Докторын зэрэг хамгаалах зөвлөл”-д хамгаалж байна. Гадаадын иргэдийг докторантурт суралцуулах үйл ажиллагааг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 113 дугаар тушаалаар баталсан дүрмээр зохицуулах болсон байна.

Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалах үйл ажиллагааг ШУА хариуцан зохион байгуулдаг бөгөөд “Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах, олгох журам”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 10 дугаар сарын 10-ны 365 тоот тушаалаар баталж, 2015 оны А/475 тоот тушаал, 2017 оны А/222 тоот тушаалуудаар нэмэлт өөрчлөлтүүдийн оруулсан байна. Энэхүү журмын 2.2, 2.3 дугаар заалтын дагуу ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/35 тоот тушаалаар Шинжлэх ухааны доктор хамгаалуулах зөвлөлийг холбогдох Бага чуулганы дэргэд 15 чиглэлээр дөрвөн жилийн хугацаатай байгуулсан ажээ.

- **Соёл, урлаг судлалын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байдал**
“Монголын соёл, урлаг судлалын тойм” (2024) төслийн хүрээнд бичсэн СУСХ-

ийн хамтын “Монгол Улсад соёл, урлаг судлалаар докторын зэрэг хамгаалсан бүтээлийн тойм (1978-2024)” (УБ., 2025.- 22,8х.х.) эмхэтгэлд тулгуурлан соёл, урлаг судлалын чиглэлээр Монгол Улсад хамгаалсан докторын зэргийн чиглэл, тоог нэгтгэн үзэв (Хүснэгт 1, 2).

Хүснэгт 1. Монгол Улсад урлаг судлалаар хамгаалсан доктор

№	Хамгаалсан чиглэл	Докторын тоо	
		(Ph.D)	(Sc.D)
1	Дүрслэх урлаг судлал	32	2
2	Хөгжим судлал	36	2
3	Театр судлал	8	
4	Бүжиг судлал	6	
5	Цирк судлал	1	
6	Кино судлал	3	
7	Радио, телевиз судлал	1	
Нийт		87	4

Хүснэгт 2. Монгол Улсад соёл судлалаар хамгаалсан доктор

№	Хамгаалсан чиглэл	Докторын тоо	
		(Ph.D)	(Sc.D)
1	Соёлын түүх, онол	22	
2	Соёлын өв судлал	25	1
3	Ном, номын сан судлал	3	
4	Музей судлал	4	
Нийт		54	1

2025 оны байдлаар шинжлэх ухааны доктор (Sc.D) зэргийг урлаг судлалаар 4, соёл судлалаар 1; доктор (Ph.D) зэргийг урлаг судлалаар 87, соёл судлалаар 54 хүн тус тус хамгаалсан байна. Эдгээр нь салбарын эрдэм шинжилгээ, судалгааны өсөлт, чиг хандлагыг харуулахын зэрэгцээ хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилттэй шууд холбоотой юм.

Хэлэлцүүлэг

Монгол Улсад эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцооны түүх нь улс төр, нийгмийн хөгжлийн өөрчлөлттэй салшгүй холбоотой байв. 1920-оод оны эхэн үеэс ЗХУ-ын боловсролын системийн нөлөөгөөр шинжлэх ухааны зэрэг, цолын ойлголт нутагшсан бол 1940–1990 онд энэхүү тогтолцоо дотооддоо төлөвшиж, дээд боловсролын байгууллагууд, ШУА-ийн хүрээлэнгүүдийн дэргэд хамгаалуулах зөвлөлүүд байгуулсан нь шинжлэх ухааны бие даасан хөгжилд чухал түлхэц үзүүлжээ. Энэ үеийн тогтолцоо төвлөрсөн шинжтэй, төрийн хяналттай, чанарын баталгаатай байсан ч гадаад жишгийг давтах хандлагатай байв.

1990 оноос хойш ардчиллын нөлөөгөөр боловсролын тогтолцоо шинэчлэгдэж, олон улсын (Bologna Process) жишгийн дагуу кредитэд суурилсан сургалтын систем нэвтэрч, эрдмийн зэрэг олгох эрхийг дээд сургуулиуд өөрийн хүрээнд хэрэгжүүлдэг болсон. Энэ нь шинжлэх ухааны хөгжил, академик бие даасан

байдлыг дэмжсэн ч чанарын баталгааны тогтолцоо сулрах, стандартын ялгаа үүсэх зэрэг сорилт бий болгосон.

Соёл, урлаг судлалын чиглэлээр 1978 оноос эхлэн урлаг судлалын ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалуулснаар тус салбарын шинжлэх ухааны статустай болох, үндэсний судалгааны өвийг хамгаалах суурь нөхцөл бүрдэж эхэлсэн. Өдгөө Соёл урлагийн их сургууль болон ШУА-ийн Бага чуулганы дэргэд докторын зэрэг хамгаалах зөвлөлүүд тогтмол ажиллаж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц судлаачдыг бэлтгэж байна.

Хэлэлцүүлгийн хүрээнд дүгнэвэл, Монгол Улсад эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцоо нь 1) эхний үед гадаад нөлөөнд тулгуурласан, 2) дараагийн үед төрийн төвлөрсөн зохицуулалттай, 3) өнөөгийн шатанд олон улсын стандарт руу шилжиж буй гэсэн гурван үндсэн үе шатаар хөгжжээ. Цаашид чанарын баталгааг сайжруулах, олон улсын хүлээн зөвшөөрлийг нэмэгдүүлэх, судалгааны санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах нь зайлшгүй шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол Улсад эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцоо нь 100 гаруй жилийн түүхтэй, шат дараалан боловсронгуй болсон онцлогтой. 1940-өөд оноос дотоодын аспирантур, хамгаалуулах зөвлөлүүд байгуулагдаж, “дэд эрдэмтэн–доктор”, “доцент–профессор” гэсэн шаталсан тогтолцоо бүрэлдэн тогтжээ. 1990-ээд оноос олон улсын Ph.D ба Sc.D зэрэгт шилжсэн нь манай эрдэмтэд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж, улмаар монголын дээд боловсрол, шинжлэх ухааны салбар дэлхийн оюуны сүлжээнд нэгтгэх боломж бүрдсэн юм.

Эрдмийн зэрэг, цол хамгаалах, олгох тогтолцоо нь зөвхөн боловсролын институт биш, харин шинжлэх ухааны чанар, мэдлэгийн үнэлэмжийг үндэсний хэмжээнд илтгэх ач холбогдолтой бүтэц юм. Иймд цаашид 1. Эрдмийн зэрэг, цолны үнэлгээний стандарт, шалгуурыг олон улсын түвшинд нийцүүлэх, 2. Судалгааны ёс зүй, нээлттэй мэдээллийн бодлогыг хэрэгжүүлэх, 3. Соёл, урлаг судлал зэрэг нийгэм–хүмүүнлэгийн чиглэлийн эрдмийн судалгааг дэмжих тусгай бодлого боловсруулах шаардлагатай байна. Ингэснээр Монгол Улсын эрдмийн зэрэг, цол хамгаалах тогтолцоо нь улам бүр боловсронгуй болж, шинжлэх ухаан, боловсролын чанарын баталгааг хангах үндсэн тулгуур хэвээр үлдэх болно.

Ашигласан материалын жагсаалт

МУУТА. БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Эрдмийн зэрэг, цол олгох улсын комиссын тогтоол. 1972.11.02. Дугаар 2. ф 287, д 2, хн 3.

МУУТА. БНМАУ-ын ШУА, Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн тогтоол. 1978.03.27. №25/18. ф 287, х 1, хн 203.

МУУТА. БНМАУ-ын Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссын тогтоол. 1987.02.15. Дугаар 01. ф 287, д 3, хн 1.

МУУТА. БНМАУ-ын СнЗ ба МАХН-ын Төв Хорооны тогтоол. 1957.12.13. Дугаар 472/204. ф 4, д 23, хн 207.

- МУУТА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1969.03.28. Дугаар 86. ф 6, д 4, хн 146.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1963.06.05. Дугаар 259. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1969.07.09. Дугаар 237. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1971.12.10. Дугаар 400. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1973.08.17. Дугаар 310. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1977.04.01. Дугаар 94. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1981.12.11. Дугаар 359. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. БНМАУ-ын СнЗ-ийн тогтоол. 1984.01.06. Дугаар 02. ф 1, д 27, хн 1.
- МУЗГА. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 1992.05.06. Дугаар 72. ф 1, д 27, хн 1.

Ном:

- Алимаа, А., Пүрэвжав, Э., Болормаа, Д., Боролзой, Д. ба бусад. 2021. *Шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэн 100 жил, 100 үйл явдал, 100 эрдэмтэн*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл. 1958. *БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхэтгэл 1957 он*. Улаанбаатар: Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэр.
- Лхамцэрэн, Б. 2017. “Монгол Улсын эрдмийн зэрэг, цол олгох тогтолцооны үүсэл, хөгжлийн тойм (1921-1990 он хүртэл).” *Боловсрол судлал сэтгүүл 2017/ (09) 137*: 13-21.
- СУСХ. 2025. *Монгол Улсад соёл, урлаг судлалын докторын зэрэг хамгаалсан бүтээлийн тойм (1978-2024)*. Ред. Алтанцэцэг Ч., Золзаяа М. Улаанбаатар: Адмон ХХК
- Сүхтоогоо, Д. 2010. *Соёл урлагийн их сургууль*. Улаанбаатар: Интерпресс ХХК.
- Төмөр-Очир, С., Ринчинбазар, Р., Дэлгэржаргал, П. 2012. *Монгол Улсын их сургууль 70 жил*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- Энэбиш, Ж. 2018. *Баримтат өвийн судлал*. Улаанбаатар: Адмон ХХК.